

## **ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ 7059106.MN САЙТ БОЛОН 7059106 УТСАНД ИРСЭН САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2016 ОНЫ ТАЙЛАН**

Аймгийн Засаг даргатай 21 хоног тутамд зохион байгуулдаг “21 хоногийн уулзалт”-ыг “Хууль тогтоомжийн хэрэгжилт, Сайнцагаан сумаас зохион байгуулж байгаа ажлын мэдээлэл, Ахмадуудтай хийх уулзалт сэдвээр 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 507 иргэн хамрагдлаа.

Уулзалтанд биечлэн 14, саналын хуудсаар 43 нийт 57 санал хүсэлт ирж аймгийн Засаг дарга С.Од-Эрдэнэ, 15 төрийн байгууллага, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нар оролцож иргэний сонирхсон асуултанд хариултыг газар дээр нь өглөө.

Аймгийн Засаг даргатай 21 хоног тутамд зохион байгуулдаг “ 21 хоногийн уулзалт”-ыг нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, ахмадуудынхаа үгийг сонсоё сэдвээр 2 удаагийн уулзалт зохион байгуулж 340 гаруй иргэд хөдөлмөрчид, төрийн албан хаагчидтай уулзалт хийсэн. Уулзалтанд бичгээр 28, амаар 9 нийт 37 санал хүсэлтийг аймгийн Засаг дарга, холбогдох байгууллагуудын удирдлагуудад иргэд тавьж хариултыг нь авсан байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар 7059106 утас буюу цахим өргөдөл гомдлын программд 222 санал хүсэлт бүртгэгдсэнээс 85% нь шийдвэрлэгдсэн байна. Бүртгэгдсэн санал хүсэлтийн гол агуулга нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, хог, газрын маргаан, хүнсний захын үйл ажиллагаа, ундны усны худгийн цагийн хуваарь, архины дэлгүүрийн цагийн хуваарь, зөвшөөрлийн тухай, малын хулгай, хог, НӨАТ-ын баримт хэвлэж өгөх тухай, цахилгаан эрчим хүчний байцаагчдын ажлын тухай, өрхийн эмнэлгийн үйл ажиллагаа, цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаа, тамхины хуулийн тухай гэх зэрэг асуудлууд байгаагаас НӨАТ-ын баримтыг ААН-үүд хэвлэж өгөхгүй, иргэдэд чирэгдэл учруулж байна гэх асуудал ихэнх хувийг эзэлж байна. Мөн халаалт дулаантай холбоотой санал гомдол нэлээдгүй байна.

2016 оны 10 сараас иргэдээс гомдол, санал, хүсэлт авдаг 7059106.mn сайт ажиллахгүй байгаа учир 7059106 утсаар гомдол санал хүлээн авч ABLE программаар холбогдох алба хэлтэс, ажилтнуудад уламжилж шилжүүлж байна.